# "ӨВСНИЙ ҮНДЭС-ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ" ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙГ ҮЗЭГЛЭВ

2012 онд Монгол Улс болон Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ой тохиож байгаа ба "Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах" хөтөлбөрийн 400 дахь төслийн ойн ёслолын арга хэмжээ Улаанбаатар хот дахь Японы Элчин сайдын яаман дээр зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээний эхэнд "Өвсний үндэс" хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих дөрвөн төслийг үзэглэжээ. Үүнд, П.Н.Шастины нэрэмжит төв эмнэлгийн Хүлээн авах, яаралтай тусламжийн тасгийн их засварын төсөлд 99.843, нийслэлийн Хан-Уул дүүргийн 134 дүгээр цэцэрлэгийн их засварын төсөлд 99.071, Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын сургуулийн дотуур байрны барилга барих төсөлд 109.281, "Байгаль-Эх" лицей ахлах сургуулийн барилгын өргөтгөлийн төсөлд 99.545 ам.долларыг зарцуулах аж.

Үүний дараа Япон улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд ноён Такенори Шимизу тус арга хэмжээнд хүрэлцэн ирсэн албаны хүмүүст талархал дэвшүүлж, үг хэлэв. Тэрбээр хэлэхдээ Япон улсын Засгийн газрын хувьд энэхүү тэмдэглэлт ойн жилийг тус хоёр орны харилцааг улам эрчимжүүлэх боломж хэмээн ойлгон, хамтын ажиллагаагаа салбар бүрт нягтруулж, "Стратегийн түншлэл" бүхий улсууд болох чиглэлд ажиллаж байгаа талаар мэдэгдлээ. Тус арга хэмжээнд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Гадаад харилцааны дэд сайд Г.Тэнгэр, Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд



Б.Унцармаа болон албаны бусад хүмүүс оролцож, үг хэлсэн. Мөн Эрүүл мэндийн яамнаас Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Янжмаа, тус хэлтсийн мэргэжилтэн Б.Туяа, П.Н.Шастины нэрэмжит төв эмнэлгийн захирал Б.Батчулуун болон харьяа эмнэлэг, төвийн дарга, захирлууд оролцлоо.